

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-/18/2023-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.10 № 01/40
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Татварын хэлтэс 3 шатны орлогын бүрдүүлэлтийн төлөвлөгөөг нийт 127,9 хувиар, үүнээс сум, орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 127,7 хувь, аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 140,8 хувь, улсад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 110,1 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Татварын хэлтэс тайлант онд 122 удаагийн сургалт зохион байгуулахад жижиг сегмент 507, бичил сегмент 560, хувь хүн 3,500 нийт 4,567 татвар төлөгч хамрагдаж, фейсбүүк хуудсанд 511 мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгаа байршуулснаас 29,144 лайк, шээр хийж, 243,205 хүн хандалт хийн, тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар 4,600 татвар төлөгчдөд масс мессеж илгээн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор 16 нэр төрлийн 19,241.4 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасаж, акталж устгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	102,589,504.91	104,335,859.91
35	БАРАА МАТЕРИАЛ	102,589,504.91	104,335,859.91
35100	Түүхий эд материал	493,130.00	442,970.00
35130	Эм боох материал	493,130.00	442,970.00
35400	Хангамжийн материал	102,096,374.91	103,892,889.91
35410	Бичиг хэргийн материал	13,051,880.21	15,091,800.21
35420	Аж ахуйн материал	83,141,579.64	83,214,489.64
35430	Сэлбэг хэрэгсэл	0	1,920,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,207,715.06	0.06
35450	Барилгын засварын материал	23,500.00	23,500.00
35470	Бусад хангамжийн материал	3,671,700.00	3,643,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	532,616,569.89	412,917,390.65
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	532,616,569.89	412,917,390.65
39200	Биет хөрөнгө	516,716,569.89	397,017,390.65
39201	Барилга, байгууламж, орон сууц	280,441,881.76	280,441,881.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,265,483.09	-28,356,365.09
39203	Авто-тээврийн хэрэгсэл	165,000,000.00	165,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-69,992,330.28	-81,835,839.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	334,438,891.67	321,891,351.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-195,909,812.72	-278,650,643.88
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,170,626.64	53,476,684.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,256,553.74	-35,219,183.94
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,250,000.00	20,250,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,507,467.35	-21,327,312.18
39217	Ном	1,346,817.00	1,346,817.00
39300	Биет бус хөрөнгө	15,900,000.00	15,900,000.00
39301	Програм хангамж	830,550.00	830,550.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-830,550.00	-830,550.00
39303	Бусад биет бус хөрөнгө	15,900,000.00	15,900,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	635,206,074.80	517,253,250.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	635,206,074.80	517,253,250.56
51	Засгийн газрын хувь оролцоо	635,206,074.80	517,253,250.56
51100	Засгийн газрын оруулсан капитал	346,465,028.90	346,465,028.90
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	346,465,028.90	346,465,028.90
51200	Хуримтлагдсан үр дүн	235,538,525.02	117,585,700.78
51210	Өмнөх үеийн үр дүн	289,348,278.36	235,538,525.02
51220	Тайлант үеийн үр дүн	-53,809,753.34	-117,952,824.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	53,202,520.88	53,202,520.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	635,206,074.80	517,253,250.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,079,645,658.00	1,018,771,563.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,065,258.00	4,995,663.58
120	Нийтлэг татварын бус орлого	80,065,258.00	4,995,663.58
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	66,489,948.00	4,995,663.58
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,575,310.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	999,580,400.00	1,013,775,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	999,580,400.00	1,013,775,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	999,580,400.00	1,013,775,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,133,455,411.34	1,136,724,387.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,133,455,411.34	1,136,724,387.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	973,146,396.12	889,828,984.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,574,515.60	546,664,117.57
210101	Үндсэн цалин	392,133,594.69	359,561,796.75
210102	Нэмэгдэл	114,991,797.43	74,660,729.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,476,628.92	56,493,477.27
210104	Урамшуулал	56,972,494.56	55,948,113.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,389,254.91	68,742,959.15
210201	Тэтгэврийн даатгал	55,941,674.31	46,901,052.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,217,181.25	5,469,926.70
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,945,794.04	4,365,861.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,207,154.31	1,091,465.40
210205	Эрүүл мэндийн даатгал	12,077,451.00	10,914,653.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,254,024.00	45,665,412.26
210301	Гэрэл, цахилгаан	4,164,962.00	5,139,712.26
210302	Түлш, халаалт	35,775,700.00	38,125,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,313,362.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,502,637.90	20,710,167.68
210401	Бичиг хэрэг	11,563,298.09	5,671,630.00
210402	Тээвэр, шатахуун	4,538,245.00	3,854,515.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,293,610.29	3,922,337.10
210404	Ном, хэвлэл	33,300.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	251,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,823,184.52	7,021,685.58

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	422,800.00	799,851.00
210604	Урсгал засвар	422,800.00	799,851.00
2107	Томилолт, зочны зардал	4,220,000.00	1,294,800.00
210702	Дотоод албан томилолт	4,220,000.00	1,294,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,038,201.98	82,995,831.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,943,686.98	82,653,686.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	158,895.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,920.00	175,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,150,000.00	0
210807	Газрын төлбөр	47,700.00	47,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,744,961.73	122,955,845.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	181,026.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,710,000.00	3,075,640.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	124,034,961.73	119,699,179.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,309,015.22	246,895,402.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,014,918.00	50,527,526.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,334,918.00	50,527,526.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,294,097.22	196,367,876.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,294,097.22	196,367,876.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-53,809,753.34	-117,952,824.24
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-53,809,753.34	-117,952,824.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	999,580,400.00	1,013,775,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	999,580,400.00	1,013,775,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	999,580,400.00	1,013,775,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	999,580,400.00	1,013,775,900.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	999,580,400.00	1,013,775,900.00
299990	Устгал	0	0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	999,580,400.00	1,013,775,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,271,384.78	766,880,497.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	622,574,515.60	546,664,117.57
210101	Үндсэн цалин	390,467,131.69	366,403,334.67
210102	Нэмэгдэл	116,658,261.11	67,623,286.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,476,628.92	56,373,477.27
210104	Урамшуулал	56,972,493.88	56,264,019.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	80,389,254.91	68,742,959.15
210201	Тэтгэврийн даатгал	55,941,674.31	46,723,604.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,217,181.25	5,542,638.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,945,794.04	4,393,790.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,207,154.31	1,098,447.82
210205	Эрүүл мэндийн даатгал	12,077,451.00	10,984,477.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	42,254,024.00	45,665,412.26
210301	Гэрэл, цахилгаан	4,164,962.00	5,139,712.26
210302	Түлш, халаалт	35,775,700.00	38,125,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,313,362.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,118,388.29	16,231,736.10
210401	Бичиг хэрэг	6,560,000.00	3,955,450.00
210402	Тээвэр, шатахуун	4,356,000.00	2,933,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,495,130.29	3,922,337.10
210404	Ном, хэвлэл	214,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	751,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,742,258.00	5,180,149.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,798,000.00	2,220,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	998,000.00	0
210604	Урсгал засвар	800,000.00	2,220,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,220,000.00	1,294,800.00
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	4,220,000.00	1,294,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,597,201.98	82,995,831.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,952,686.98	82,653,686.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	158,895.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,920.00	175,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,700,000.00	0
210807	Газрын төлбөр	47,700.00	47,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,320,000.00	3,065,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,320,000.00	3,065,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,309,015.22	246,895,402.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,014,918.00	50,527,526.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,334,918.00	50,527,526.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00	0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	76,294,097.22	196,367,876.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,294,097.22	196,367,876.94
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	289,348,278.36	689,015,828.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	289,348,278.36	689,015,828.14
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-53,809,753.34	-53,809,753.34
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	235,538,525.02	635,206,074.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	235,538,525.02	635,206,074.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	235,538,525.02	635,206,074.80
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-117,952,824.24	-117,952,824.24
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	346,465,028.90	53,202,520.88	117,585,700.78	517,253,250.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,013,775,900.00	817,408,023.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,013,775,900.00	817,408,023.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	963,248,300.00	766,880,497.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	719,941,900.00	546,664,117.57
210101	Үндсэн цалин	429,352,200.00	366,403,334.67
210102	Нэмэгдэл	138,387,500.00	67,623,286.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	71,148,000.00	56,373,477.27
210104	Урамшуулал	81,054,200.00	56,264,019.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,992,700.00	68,742,959.15
210201	Тэтгэврийн даатгал	61,195,100.00	46,723,604.14
210202	Тэтгэмжийн даатгал	7,199,400.00	5,542,638.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,759,500.00	4,393,790.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,439,900.00	1,098,447.82
210205	Эрүүл мэндийн даатгал	14,398,800.00	10,984,477.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,680,400.00	45,665,412.26
210301	Гэрэл, цахилгаан	5,154,700.00	5,139,712.26
210302	Түлш, халаалт	38,125,700.00	38,125,700.00
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,685,000.00	16,231,736.10
210401	Бичиг хэрэг	4,155,900.00	3,955,450.00
210402	Тээвэр, шатахуун	2,933,800.00	2,933,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,922,500.00	3,922,337.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	264,800.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,408,000.00	5,180,149.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,882,700.00	2,220,000.00
210604	Урсгал засвар	2,882,700.00	2,220,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,565,200.00	1,294,800.00
210702	Дотоод албан томилолт	1,565,200.00	1,294,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	83,032,900.00	82,995,831.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,653,700.00	82,653,686.98
210803	Даатгалын үйлчилгээ	133,500.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,000.00	175,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	47,700.00	47,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,467,500.00	3,065,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,467,500.00	3,065,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,527,600.00	50,527,526.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,527,600.00	50,527,526.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,527,600.00	50,527,526.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,013,775,900.00	1,013,775,900.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,013,775,900.00	1,013,775,900.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,013,775,900.00	1,013,775,900.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	40
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	47	35
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	0	0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Татварын хэлтэс нь 4 тасаг, 52 орон тоо батлагдсанаас 40 орон тоогоор үйл ажиллагаа явуулж, сумдад 12 орон тоо дутуу ажилласан байна.

Төв аймгийн Татварын хэлтэс төсвийн орлогын бүрдүүлэх, татварын хувь тогтоомжийг татвар төлөгчдөд сурталчлах, татварын хуулийн хэрэгжилтэд аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналт тавих чиг үүрэгтэйгээр, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгоор ажилласан байна.

Төв аймгийн Татварын хэлтэс нь тайлант онд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Татварын албаны эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн зарчмыг баримтлан, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэн, татварын албаны үйл ажиллагааны зорилт
- Төв аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд татварын асуудлаар тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулах, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татварын сургалт, сурталчилгааны ажлыг өргөтгөж, татварт хамрагдалтын түвшин дээшлүүлэх, татварын өр барагдуулалтын ажлыг эрчимжүүлэх
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг үр нөлөөтэй болгох, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгон бэхжүүлэх үндсэн дээр улс, орон нутгийн төсвийг жигд ханган биелүүлэх.

Төв аймгийн Татварын хэлтэс 3 шатны орлогын бүрдүүлэлтийн төлөвлөгөөг нийт 127,9 хувиар, үүнээс сум, орон нутагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 127,7 хувь, аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 140,8 хувь, улсад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 110,1 хувиар тус тус биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Татварын хэлтэс тайлант онд 122 удаагийн сургалт зохион байгуулахад жижиг сегмент 507, бичил сегмент 560, хувь хүн 3,500 нийт 4,567 татвар төлөгч хамрагдаж, фэйсбүүк хуудсанд 511 мэдээ, мэдээлэл, сургалт сурталчилгаа байршуулснаас 29,144 лайк, шээр хийж, 243,205 хүн хандалт хийн, тайлангаа хуулийн хугацаанд ирүүлэх талаар 4,600 татвар төлөгчдөд масс мессеж илгээн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Татварын хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Татварын ерөнхий хуулийн зарим заалтуудад 2022 оны 6 дугаар сарын 17-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 5, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус хэлтэст дотоод аудит байхгүй бөгөөд Татварын ерөнхий газрын дэргэдэх Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газраас дотоод хяналтыг гүйцэтгэдэг байна. Тайлант онд Татварын ерөнхий газрын дэргэдэх Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газраас дотоод хяналт шалгалтыг хийсэн ч энэ талаарх дүгнэлт, тайлан, зөвлөмж ирүүлээгүй байна.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Татварын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дүгээр сарын 12-ний өдрийн №А/56 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2020 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт Татварын салбарын бүртгэл тайлагналын онцлог гэсэн 4 дэд бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 117,952.8 мянган төгрөгөөр буюу 18,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал	102,589.4	104,335.8	1,746.4
Үндсэн хөрөнгө	532,616.6	412,917.4	-119,699.2
Нийт хөрөнгө	635,206.0	517,253.2	-117,952.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	635,206.0	517,253.2	-117,952.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	635,206.0	517,253.2	-117,952.8

Дээрх хүснэгтээс харахад, Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 102,589.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,746.4 мянган төгрөг буюу худалдан авсан хөрөнгө 1,746.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 532,616.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 412,917.4 мянган төгрөг болж, 119,699.2 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Тайлант онд Төрийн өмчийн, бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 9-ны өдрийн 294 дүгээр тогтоолоор 16 нэр төрлийн 19,241.4 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасч,

акталж устгасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 517,253.2 мянган төгрөг болж 117952.8 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,084,553.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас үндсэн үйл ажиллагааны зардлыг 70,777.7 мянган төгрөгөөр бууруулж, 1,013,775.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг бууруулсан дүнгээр буюу улсын төсвөөс 1,013,775.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр Татварын Ерөнхий газраас ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,013,775.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,013,775.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 196,367.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 817,408.1 мянган төгрөг буюу 80,6 хувьтай байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын төсвийг 194,527.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 14.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 453.2 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 662.7 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 270.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний бусад зардал 438.9 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70205-80101	880,594.6	684,226.8	196,367.8	77.7
2	70205-80219	21,600.0	21,600.0	0	100.0
3	70205-80220	61,053.7	61,053.7	0	100.0
4	70205-80802	50,527.6	50,527.6	0	100.0
	Дүн	1,013,775.9	817,408.1	196,367.8	80.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд нэмэлт төсвийн дансаар мөнгө зарцуулаагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70205	2022.01.01 2022.12.31	Татвар ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэн ба хуулийн этгээдийн тайланг чанартай хүлээн авах, сургалт сурталчилгаа хийх, татварын орлогыг нэр төрөл бүрээр ханган биелүүлэх, татвар төлөгч иргэн, хуулийн этгээдийг хуулийн дагуу хөнгөлөлт чөлөөлт эдлүүлэх, буцаан олголтыг хууль журмын дагуу олгох.	Татварын орлогын бүрдүүлэлт 80,6%	1,013,775.9	817,408.1

Төв аймгийн Татварын хэлтсийн үндсэн үйл ажиллагааны зардал 77,7 хувийн хэрэгжилттэй буюу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 194,527.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Тус байгууллагын татварын орлогын бүрдүүлэлт хөтөлбөр 80,6 хувь буюу 19,4 хувиар дутуу хэрэгжсэн нь орон тоо бүтэц 40 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж, Зуунмод болон бусад сумдад 12 орон тоо дутуу, энэ нь төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад тэнцсэн нөөцөд бүртгэлтэй мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн дансны мэдээлэл хугацаандаа байршуулсан эсэхтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг Татварын ерөнхий газраас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Татварын ерөнхий газраас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг 2022 оны 1,013,775.9 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 10,137.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,096.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Татварын хэлтэс нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Татварын хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 75,0%-тай, 5,0 саяас дээших орлогын 12 гүйлгээ, зарлагын 1 гүйлгээ, хугацаандаа байршуулж, 7,022.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Татварын хэлтсийн 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар үр ашиггүй зарцуулсан 256.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, ЗГ-ын 43 дугаар тогтоол, үндсэн хөрөнгө, санхүүгийн программ хангамжтай холбоотой 3 албан шаардлага өгөгдсөнийг 100%, зөвшөөрөгдсөн санхүүгийн программ хангамж ашиглах, шилэн данс, үндсэн хөрөнгөтэй холбоотой 3 зөвлөмж өгөгдсөнийг 66,7% хэрэгжүүлэн Төв аймгийн Татварын хэлтсийн даргын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 05/508 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	256,2	1	256,2	100
Албан шаардлага	3	32,385.0	3	32,385.0	100
Зөвлөмж	3	0	2	0	66.7
Нийт дүн	7	32,641.2	7	32,641.2	

Тус байгууллага төсөвт байгууллагад зөвшөөрөгдсөн Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжаар бүртгэлийг хөтөлж, тайлагнахгүй байгааг таслан зогсоох зөвлөмж хэрэгжээгүй нь Татварын ерөнхий газрын хэмжээнд мөрдөж байгаа учраас өөрчлөх боломжгүйгээс шалтгаалжээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Татварын хэлтэст дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,074.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 9,052.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 7,022.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1.Тус байгууллага тайлант онд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зар сурталчилгаа явуулж, богино хэмжээний нэвтрүүлэг хийх, сургалтын хөлс, сурталчилгааны зардалд 1,863.0 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2.Тус байгууллага тайлант онд төсвийн хөрөнгөөр цай, кофе, чихэр, печень, 00 цаас болон бусад шаардлагагүй бараа материал 762.1 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3.Тус байгууллага тайлант онд бичиг хэргийн зардлыг хэмнээгүй хэвлэгчийн хор, дэвтэр, сургалтын материал, маузны суурь, бичиг хэргийн материал 6,427.4 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д “бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2. Тус байгууллага тайлант онд шилэн дансанд зарлагын 7,022.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ байршуулаагүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зар сурталчилгаа явуулж, богино хэмжээний нэвтрүүлэг хийх, сургалтын хөлс, сурталчилгааны зардалд зарцуулсан.	1	1,863.0			1	1,863.0		
Төсвийн хөрөнгөөр цай, кофе, чихэр, печень, 00 цаас болон бусад шаардлагагүй бараа материал худалдан авсан.	1	762.1			1	762.1		
Бичиг хэргийн зардлыг хэмнээгүй хэвлэгчийн хор, дэвтэр, сургалтын материал, маузны суурь, бичиг хэргийн материал худалдан авсан.	1	6,427.4			1	6,427.4		
Дүн	6	9,052.6			6	9,052.6		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/	
			Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Шилэн дансанд зарлагын 1 гүйлгээ байршуулаагүй	1	7,022.0	1	7,022.0
Дүн	1	7,022.0	1	7,022.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
Дүн				
Нийт дүн	1	7,022.0	1	7,022.0

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn